



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Өндөрхаан хот тохижилтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/013/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Чингис хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Г.Энх-Амгалан
Утас: 91119424

Цахим хаяг: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.03.13 № 471

танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ӨНДӨРХААН
ХОТ ТОХИЖИЛТ ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Э.МӨНХБАТ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хэнтий аймгийн Өндөрхаан хот тохижилтын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр байна. Үүнд:

- Анхан шатны баримтгүйгээр 2,940.3 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан;
- Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, орон нутагт ажилласны нэмэгдэлд 221,950.2 мянган төгрөгийг олгосон;
- Ажилчдын цалингаас 11,067.1 мянган төгрөгийг суутгасан;

Дээрх зөрчлүүд нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйл. "Цалин хөлснөөс хийх суутгал, түүний хэмжээг хязгаарлах", 119.1. "Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно", ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, ЗГ-ын 2024 оны 82 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам"-ын 1.1. "Төрийн албан хаагчдыг орон нутагт ажиллах сонирхлыг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгоход энэ журмыг баримтална", Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйл. "Цалин хөлснөөс хийх суутгал, түүний хэмжээг хязгаарлах", 119.1. "Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно" гэснийг зөрчсөн нь санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Өндөрхаан хот тохижилтын газрын хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэр нь орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-д “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ” гэж заасан боловч тус газар нь орон нутгийн төсвөөс санхүүжиж байна. Иймд тус байгууллагын хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэрийг авч үзэх, шаардлагатай өөрчлөлтийг хийж зөрүүг арилгах нь зүйтэй.

Аудитын гол асуудал

Аудитаар нийт 989,958.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 31,821.5 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 2,940.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 955,196.6 мянган төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, хуулийн этгээдийн эд хөрөнгийн эрхийн байдал, улсын бүртгэлтэй холбоотой зөрчилд 1 зөвлөмж хүргүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, гүйцэтгэлийг үнэлүүлээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. Аудитын илрүүлэлт.....	9
3.1 Төлбөрийн акт	9
3.2 Албан шаардлага	9
3.3 Зөвлөмж.....	10
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	11

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	248,869,360.60	462,374,618.44
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
33	АВЛАГА	59,220.60	3,846,091.84
335	Бусад авлага	59,220.60	3,846,091.84
3351	Байгууллагаас авах авлага	59,220.60	3,846,091.84
34	УРЬДЧИЛГАА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	248,810,140.00	458,528,526.60
351	Түүхий эд материал	-	-
354	Хангамжийн материал	248,810,140.00	458,528,526.60
35410	Бичиг хэргийн материал	675,000.00	2,209,220.60
35420	Аж ахуйн материал	204,122,640.00	355,882,706.00
35430	Сэлбэг хэрэгсэл	12,163,000.00	54,792,650.00
35440	Түлш, шатах тослох материал	-	14,524,450.00
35450	Барилгын засварын материал	31,849,500.00	31,119,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	38,407,105,901.70	41,440,460,127.66
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	38,407,105,901.70	41,440,460,127.66
392	Биет хөрөнгө	37,319,492,901.70	40,352,847,127.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	26,357,894,779.92	27,011,573,628.92
39202	Хуримтлагдсан элэгдэл	(8,493,488,929.46)	(10,115,513,824.15)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,034,005,920.00	2,492,845,920.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,030,495,887.86)	(1,213,907,436.09)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	490,985,730.00	1,635,464,948.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(182,782,650.67)	(161,026,629.69)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,814,420.76	25,494,615.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,952,546.00)	(4,152,407.71)
39209	Зам, гүүрийн байгууламж	19,328,544,171.07	23,239,690,851.07
39210	Хуримтлагдсан элэгдэл	(2,029,200,459.93)	(3,317,124,292.28)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	479,087,123.00	479,087,123.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	439,083,000.00	439,083,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(78,001,769.13)	(158,668,369.17)
393	Биет бус хөрөнгө	1,087,613,000.00	1,087,613,000.00
39301	Програм хангамж	340,000.00	340,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(340,000.00)	(340,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,087,613,000.00	1,087,613,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	38,655,975,262.30	41,902,834,746.10
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	38,655,975,262.30	41,902,834,746.10
51	Засгийн газрын хувь оролцоо	38,655,975,262.30	41,902,834,746.10
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,219,796,848.38	5,219,796,848.38
51101	Өмч: - төрийн	5,219,796,848.38	5,219,796,848.38
512	Хуримтлагдсан үр дүн	31,513,546,966.37	34,760,406,450.17
51210	Өмнөх үеийн үр дүн	31,513,546,966.37	31,515,316,966.37
51220	Тайланг үеийн үр дүн	-	3,245,089,483.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,922,631,447.55	1,922,631,447.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	38,655,975,262.30	41,902,834,746.10

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,180,975,306.00	9,915,216,692.87
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	6,727,805,052.87
120	Нийтлэг татварын бус орлого	-	6,727,805,052.87
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	6,727,805,052.87
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	6,727,805,052.87
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,180,975,306.00	3,187,411,640.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,367,506.00	118,102,440.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,400,000.00	72,504,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,967,506.00	45,598,440.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,149,607,800.00	3,069,309,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,149,607,800.00	3,069,309,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,505,370,141.19	6,666,377,208.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,505,370,141.19	6,666,377,208.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,494,347,031.19	6,545,042,831.32
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,175,342,615.40	2,864,200,710.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,175,342,615.40	2,864,200,710.67
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,319,004,415.79	3,680,842,120.65
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,319,004,415.79	3,680,842,120.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,023,110.00	121,334,377.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,745,400.00	111,534,489.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,442,900.00	111,534,489.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,302,500.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, са	277,710.00	9,799,888.49
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	277,710.00	9,799,888.49
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-3,324,394,835.19	3,248,839,484.06
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	3,750,000.26
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	3,750,000.26
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-3,750,000.26
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-3,324,394,835.19	3,245,089,483.80

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,219,796,848.38	1,922,631,447.55	31,513,546,966.37	38,655,975,262.30
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,219,796,848.38	1,922,631,447.55	31,513,546,966.37	38,655,975,262.30
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	1,764,622,851.61	1,764,622,851.61
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,219,796,848.38	1,922,631,447.55	33,278,169,817.98	40,420,598,113.91
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,219,796,848.38	1,922,631,447.55	33,278,169,817.98	40,420,598,113.91
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,770,000.00	1,770,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,219,796,848.38	1,922,631,447.55	33,279,939,817.98	40,422,368,113.91
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	3,245,089,483.80	3,245,089,483.80
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,219,796,848.38	1,922,631,447.55	36,525,029,301.78	43,667,457,597.71

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,181,614,716.00	3,187,411,640.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,181,614,716.00	3,187,411,640.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,006,916.00	118,102,440.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс до	19,400,000.00	72,504,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий бо	12,606,916.00	45,598,440.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,149,607,800.00	3,069,309,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байг	2,149,607,800.00	3,069,309,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,179,814,816.00	3,138,264,340.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,179,814,816.00	3,138,264,340.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,158,252,106.00	3,006,848,818.65
2105	Нормативт зардал	6,400,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,400,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,979,206.00	21,763,040.00
210604	Урсгал засвар	23,979,206.00	21,763,040.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураам	2,127,872,900.00	2,985,085,778.65
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний тө	2,127,872,900.00	2,985,085,778.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,562,710.00	131,415,521.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,285,000.00	117,769,541.02
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,935,000.00	116,319,541.02
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,350,000.00	1,450,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, са	277,710.00	9,799,888.49
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	277,710.00	9,799,888.49
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	3,846,091.84
213503	Нэмэлт данснаас төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,846,091.84
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,799,900.00	49,147,300.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,799,900.00	49,147,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,799,900.00	49,147,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,799,900.00	49,147,300.00
223001	Бусад хөрөнгө	1,799,900.00	49,147,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	(1,799,900.00)	(49,147,300.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангил	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,069,309,200.00	3,059,509,311.51	9,799,888.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,069,309,200.00	3,010,362,011.51	58,947,188.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,947,481,300.00	2,888,979,111.51	58,502,188.49
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний т	2,947,481,300.00	2,888,979,111.51	58,502,188.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил ү	2,947,481,300.00	2,888,979,111.51	58,502,188.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	121,827,900.00	121,382,900.00	445,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	121,827,900.00	121,382,900.00	445,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн	121,827,900.00	121,382,900.00	445,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	49,147,300.00	-49,147,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	49,147,300.00	-49,147,300.00
223001	Бусад хөрөнгө	00.00	49,147,300.00	-49,147,300.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,069,309,200.00	3,059,509,311.51	9,799,888.49
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨЭС САНХҮҮЖИХ	3,069,309,200.00	3,059,509,311.51	9,799,888.49
132001	Орон нутгийн төсвөөс	3,069,309,200.00	3,059,509,311.51	9,799,888.49

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	118,102,440.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	118,102,440.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	112,806,348.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-
2105	Нормативт зардал	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,763,040.00
210604	Урсгал засвар	21,763,040.00
2107	Томилолт, зочны зардал	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	91,043,308.16
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	91,043,308.16
211	ХҮҮ	-
212	ТАТААС	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,450,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,450,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,450,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,846,091.84
213503	Нэмэлт данснаас төвлөрүүлэх шилжүүлэг	3,846,091.84
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	118,102,440.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	118,102,440.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	72,504,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	45,598,440.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн аудитаар нийт 989,958.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч 31,821.5 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 2,940.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 955,196.6 мянган төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, хуулийн этгээдийн ангилалтай холбоотой 1 зөвлөмжийг хүргүүлээ.

Аудитаар илэрсэн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайланд 31,821.5 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залрууллаа. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тодруулга тайлгаас 31,821.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлснийг залрууллаа.

Аудитаар 958,136.9 мянган төгрөгийн зөрчил илэрч 2,940.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 955,196.6 мянган төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, улсын бүртгэлд бүртгэгдсэн байгууллагын хариуцлагын хэлбэрийг шийдвэрлэх талаар 1 зөвлөмж хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт

Аудитаар 2,940.3 мянган төгрөгийн зөрчил илэрч 1 төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Анхан шатны баримтгүйгээр 2,940.3 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

Аудитаар 955,196.6 мянган төгрөгийн зөрчил илэрч 6 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, орон нутагт ажилласны нэмэгдэлд 221,950.2 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, ЗГ-ын 2024 оны 82 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”-ын 1.1. “Төрийн албан хаагчдыг орон нутагт ажиллах сонирхлыг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгоход энэ журмыг баримтална” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Ажилчдын цалингаас 11.067.1 мянган төгрөгийг суутгасан байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйл. “Цалин хөлснөөс хийх суутгал, түүний хэмжээг хязгаарлах”, 119.1. “Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомжтой холбоотой 155,521.7 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлснийг тайлангийн 4.3-т, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 566,607.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлснийг тайлангийн 4.4.1-т тусгасан болно.

3.3 Зөвлөмж

1. Хуулийн этгээдийн эд хөрөнгийн эрхийн байдал, бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

- ✓ Тус газар нь улсын бүртгэлийн гэрчилгээнд ОНӨААТҮГ статустай боловч, байгууллагын дүрэм, санхүүжилт, хөрөнгийн эх үүсвэр нь төсөвт газрын хэлбэрээр ажиллаж байна.

Өгсөн зөвлөмж:

- ✓ Хуулийн этгээдийн өмчийн хэлбэр, дүрэм, санхүүжилт, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, холбогдох өөрчлөлтийг хийж зөрчлийг арилгах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зөрүүтэй тооцсон.	1	31,821.5			1	31,821.5	1	31,821.5				
Дүн	1	31,821.5			1	31,821.5	1	31,821.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	А/Т-ны тоо	Тоо
Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, орон нутагт ажилласны нэмэгдэлд 221,950.2 мянган төгрөгийг олгосон байна.	1	221,950.2			1	221,950.2							
Ажилчдын цалингаас 11.067.1 мянган төгрөгийг суутгасан байна.	1	11,117.1			1	11,117.1							
Анхан шатны баримтгүйгээр 2,940.3 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан.	1	2,940.3	1	2,940.3									
Байгууллагын статустай холбоотой зөрчил	1						1	-					
Дүн	4	236,007.6	1	2,940.3	2	233,067.3	1	-					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд мэдээлэл байршуулаагүй	1	566,607.7			1	566,607.7		
Дүн	1	566,607.7			1	566,607.7		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тендер зарлалгүй шууд худалдан авалт хийсэн.	1	101,403.2			1	101,403.2		
Хөрөнгө нөөцөлсөн	1	54,118.5			1	54,118.5		
Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааг эрх бүхий этгээдээр батлуулаагүй.	1	-			1	-		
Дүн	3	155,521.7			3	155,521.7		
Нийт дүн	4	722,129.4			4	722,129.4		